



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өвөрхангай, Төв аймгууд болон эдгээр аймгийн зарим сумд, Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн мониторинг

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, төсвийн зарцуулалт, зохион байгуулалтад мониторинг хийх чиглэлээр Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан /ЛЭОС/-ийн Өвөрхангай аймаг дахь салбар, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн /НДЭХ/-ий Төв аймаг дахь салбар болон Зориг санд тус тус тэтгэлэг олгосон юм. “Мониторинг” -ийн энэ дугаарт Өвөрхангай аймаг, тус аймгийн Арвайхээр, Бат-Өлзий сумд, Төв аймаг, тус аймгийн Батсүмбэр, Баянхангай, Зуунмод сумд, Улаанбаатар хотын Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл /ГХУСАЗЗ/, салбар зөвлөл /ГХУСАЗСЗ/-ийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн гол үр дүнг нийтэлж байна. Мониторингийн дүнгээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тодорхой төсөвтэй болж, үйл ажиллагаа нь тогтмолжин олон талын оролцоог хангахад анхаарч байгаа нь ажиглагдлаа.

Ажиглалт мониторинг тус бүрийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзэх боломжтой.

МОНИТОРИНГИЙН ДҮН

НЭГ. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн ажлыг аймагт ИТХ-ын Ажлын албаны мэргэжилтэн, сумдад ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хариуцдаг бөгөөд аймгийн ГХУСАЗЗ-ийн ажилтан үүнийг хавсран гүйцэтгэдэг тул ачаалал ихтэй байдгаас ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлдөг байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл бүтэц зохион байгуулалтын хувьд олон салбарын төлөөллөөс бүрдсэн нь түгээмэл байгаа хэдий ч хуралдаан, дотоод ажил нь тогтмолжоогүй, гишүүдийн идэвх, хариуцлага сул, ажил хариуцсан ажилтнуудын мэдлэг чадвар, ажлын ачаалал жигд биш байна. Тухайлбал, Төв аймгийн ГХУСАЗЗ-ийн ажилтны ачаалал их, харин сумдын хувьд хариуцсан ажилтны эрх зүйн мэдлэг дутмаг байна. Төв аймгийн ГХУСАЗЗ, сумдын салбар зөвлөл жилд дунджаар 2-3 удаа хуралдаж байгаа нь ажиллах журамд заасан сар бүр хуралдах заалтыг зөрчиж байгаагаас гадна үйл ажиллагаа тасралтгүй байх нөхцөлийг хязгаарлаж байна. Үүний зэрэгцээ хурлын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил түгээмэл байна. Өвөрхангай аймгийн тухайд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд зохион байгуулж буй уулзалт, хэлэлцүүлгийн баримтжуулалт хангалтгүй байлаа.

ГХУСАЗСЗ-ийн ажиллах журмыг ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулах ёстой хэдий ч салбар зөвлөл нь баталсан, эсхүл огт журам батлаагүй зөрчил байна. Тухайлбал, Төв аймгийн Зуунмод сумын ГХУСАЗСЗ ажиллах журмаа ИТХ-ын Тэргүүлэгчдээр биш өөрсдөө баталсан, Баянхангай, Батсүмбэр сум ажиллах журмаа батлаагүй байв.



МОНИТОРИНГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Төв аймаг

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Зохицуулах зөвлөлийн хуралдаанд оролцож, мониторингийн дүнг танилцуулав.
- Аймгийн ТБС телевизийн “Тодруулга” буланд оролцож 40 минутын хугацаанд мониторингийн талаар мэдээлэл хийлээ. Мөн “Төв-Ньюс” сонинд мониторингийн дүнг нийтэллээ.
- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн эрх, үүрэг” сэдэвт хэлэлцүүлгийг Баянхангай, Батсүмбэр, Зуунмод сумдад хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлтээ танилцууллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхдөө гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийн талаарх статистик мэдээнд суурилдаггүй; төлөвлөлтөд иргэд, олон нийтийн санал авахгүй байх нь түгээмэл ажиглагдлаа. Зарим сумын ГХУСАЗСЗ иргэдээс санал авсан гэх боловч баримтжуулаагүй тул авсан гэж үзэх боломжгүй юм. Төлөвлөлтийн явцыг харахад хүрэх түвшин тодорхойгүй, завсрын үр дүнг голчилсон, хэвшмэл хэдэн үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Тухайлбал, Багануур дүүрэгт 2015 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 31,8 хувь нь гэр бүл ахуйн хүрээнд үйлдэгдсэн ч энэ чиглэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил төлөвлөөгүй байв. Өвөрхангай аймгийн ГХУСАЗЗ, Арвайхээр, Бат-Өлзий сумын ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын төлөвлөгөөг гэмт хэргийн нөхцөл байдалтай харьцуулж үзэхэд ямар нэг байдлаар уялдуулан төлөвлөжээ гэж үзэхээр байгаа ч үйл ажиллагааны цар хүрээ, хүртээмж бага байх ажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.3.2-т зааснаар төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх үүрэгтэй хэдий ч Төв аймгийн ГХУСАЗЗ 2014-2016 онд энэ үйл ажиллагааг огт зохион байгуулаагүй байна.

Мониторингийн хүрээнд ажигласан аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан зарим ажлыг онцолж байна. Үүнд:

- Төв аймгийн Зуунмод сум гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа, хүүхдийн байгууллага, Дэлхийн зөн ОУБ, Ахмадын хороо, Оюунлаг өөрчлөлт ТББ-тай идэвхтэй хамтран ажиллаж “100 аавын чуулга уулзалт”, “Спирт биш спорт”, өршөөлөөр суллагдсан 21 хүнийг эргэж нийгэмшихэд зориулсан эрүүл мэндийн үзлэгт хамруулах, 0.7 га газар олгуулах, ажилд оруулах арга хэмжээ тус тус зохион байгуулж, сурагчдын дунд “Зуунмод сайн дурын хөтөлбөр” төслийн уралдаан зарлах зэргээр амжилттай ажилласан байна.
- Баянхангай сум орон байрны хулгайгаас сэргийлэх зорилгоор гудамжны гэрэлтүүлэг, хуулийн сурталчилгаа, сэрэмжлүүлгийг 14 зөөврийн самбараар мэдээлэх, архи хэрэглэдэггүй байгууллага, айл өрх, тэргүүний мал хамгаалах бүлгийг жил бүр шалгаруулж, урамшуулжээ.
- Батсүмбэр сум цагдаагийн байгууллагад автомашин, дагалдах тоноглол, мотор, компьютер, принтер авч өгч, сургууль болон дотуур байранд камер байршуулах, “Ардын эргүүл” 1 сарын аян, сурагчдад замын хөдөлгөөнд зөв оролцох дадлага эзэмшүүлэх сургалт зохион байгуулжээ.
- Багануур дүүргийн хувьд “Гэр бүл ба хөршийн холбоо”, “Архигүй, айдасгүй эрүүл амьдрал” хэлэлцүүлэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр бүлийн сэтгэл зүйн харилцаа”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Залуу гэр бүлийн сургалт” зохион байгуулжээ.
- Өвөрхангай аймаг 2016 оныг “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, мөн “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөр хэрэгжүүлсний дүнд хулгайн болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт буурчээ.



ХОЁР. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨВ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ

Төв аймгийн ГХУСАЗЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалтын тайлан гаргах маягт батлан сумдын салбар зөвлөлд хүргүүлж, тайланг нэг мөр гаргаж хэвшжээ. Аймгийн ГХУСАЗЗ нь төсвийн дийлэнхийг эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтийг хамарсан арга хэмжээ, байгууллага, иргэдийн урамшуулал, сумдын зөвлөлийг чадавхжуулах сургалт, семинарт зарцуулсан байна. Харин Өвөрхангай аймгийн тухайд нийт төсвийн 60 орчим хувийг олон нийтийн цагдаагийн ажилтан, иргэний зөвлөлийн гишүүдийн урамшуулалд, үлдсэн 40 хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулжээ. Сумдын салбар зөвлөлийн тухайд Төв аймгийн Зуунмод сумын хувьд төсвийн дийлэнх буюу 55,6-78 хувь нь олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалд, Баянхангай сум 2014 онд 70 хувь, 2015 онд 71 хувийг гэрэлтүүлэг тавих, эргүүл жижүүрийн урамшуулалд, Батсүмбэр сум 2014 онд төсвийн давсан орлогоос цагдаагийн байгууллагад 16 сая төгрөгөөр автомашин, 300 000 төгрөгөөр дагалдах тоноглол, 2016 онд 1,8 сая төгрөгөөр цагдаагийн байгууллагад машины мотор, компьютер, принтер авч өгч, сургууль, дотуур байрыг камержуулахад зарцуулжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санхүүжилт олох чиглэлээр Өвөрхангай аймгийн Арвайхээр сум санаачилга гаргаж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 16 дугаар тогтоолоор байгууллага, аж ахуйн нэгж тус бүрээс улиралд 20 000 төгрөг гаргуулж, нийт 9 520 000 төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, нийт 2 520 000 төгрөгийг бүрдүүлсэн байна. Тухайн төвлөрүүлсэн хөрөнгөөр “Эрчүүдээ хайрлая” өртөөчилсөн аян, “Эмэгтэйчүүдээ дэмжье” кофетой уулзалт, иргэн, олон нийтийн зөвлөлийн урамшуулал, эргүүлийн шатахуунд зарцуулжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон талын оролцоог хангаж, төсөв бүрдүүлэх санаачилга өрнүүлж байгаа нь сайшаалтай ч аймгийн ГХУСАЗЗ-өөс 2015 онд орж ирсэн 500 000 төгрөг, орон нутгийн төсвөөс 2016 оны 10 дугаар сард орсон 3 600 000 төгрөгийг тухайн ондоо зарцуулаагүй байна. Үүнээс 3 600 000 төгрөг орон нутгийн ерөнхий орлогод буцсан байна. Бат-Өлзий сумын тухайд 2016 онд 4 733 500 төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зарцуулахаар төсөвлөснөөс 1 733 500 төгрөгийг журмын хашааны сахиулын цалинд, 2 467 000 төгрөгийг цагдаагийн хэсэгт бэлэн бус торгуулийн машин худалдаж авахад, 533 000 төгрөгийг сургалт, сурталчилгаанд зарцуулжээ.

Багануур дүүргийн тухайд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал хуваарилагддаггүй бөгөөд жил бүр тогтмол төсөв хуваарилагддаг байна. Үүний зэрэгцээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсвийн зарцуулалтад ГХУСАЗСЗ-ийн гишүүдийн оролцоо хангалтгүй байдаг ажээ. Тухайлбал, 7 гишүүн буюу нийт гишүүдийн 80 хувь ярилцлагад хамрагдсанаас 57 хувь нь төсвийн зарцуулалтын талаар мэдэхгүй гэж хариулжээ. Мөн түүнчлэн төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагааг дэмжиж томилолтын зардал, тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт зарцуулах нь түгээмэл байна. Жишээ нь, 2014 онд Замын цагдаагийн тасагт компьютер авахад 1 523 000 төгрөг; 2015 онд прокурорт зөөврийн компьютер авахад 1 550 000; i-pad, камер авахад 1 563 800 төгрөг тус тус зарцуулжээ. Энэ нь 2014 оны төсвийн 15 хувь, 2015 оны төсвийн 31 хувьтай тэнцэж байгаа нь бага биш дүн

МОНИТОРИНГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Өвөрхангай аймаг

- Мониторингийн зөвлөмжийн хүрээнд аймгийн ГХУСАЗЗ-ийн 2016 оны үйл ажиллагааг иргэдийн оролцоотой, үр дүнд суурилан үнэлж 2017 оны үйл ажиллагаанд санал авах зорилгоор Арвайхээр сумын ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, Багийн ажлын албатай хамтран 100 гаруй иргэд, Баянгол, Баян-өндөр, Сант, Тарагт, Төгрөг, Хархорин, Хужирт сумдын ГХУСАЗСЗ-ийн дарга нар оролцсон хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр мониторингийн дүнг танилцуулав.
- Мониторингийн дүнг “Гурвалжин мэдээ” сонинд нийтлүүлжээ.



юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг урьдчилан баталж зарцуулдаггүй бөгөөд аль нэг дутсан зардлыг санхүүжүүлэх байдлаар ажилладаг болох нь мониторингийн явцад ажиглагдлаа.

ЗӨВЛӨМЖ

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл, Салбар зөвлөлийн ажиллах журмыг тухайн шатны ИТХ батлан мөрдүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлахдаа тухайн орон нутгийн онцлог, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, иргэдийн оролцоонд тулгуурлан төлөвлөж төлөвлөгөө, төсвийг ГХУСАЗЗ, ГХУСАЗСЗ-ийн хурлаар хэлэлцэж батлах, хэрэгжилтийн болон зарцуулалтын тайланг олон нийтэд хүртээмжтэй тайлагнах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах Зөвлөл, Салбар зөвлөлийн гишүүдэд зориулсан гарын авлага боловсруулах, сургалтад хамруулах;
- Бие биеэсээ харилцан суралцах, сайн туршлагаа солилцох боломжийг олгох үүднээс жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн “Сайн туршлага”-ыг шалгаруулж, түгээх;
- Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан орон тооны ажилтантай болгох;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, энэ зорилгоор орон нутгийн ТББ-уудтай үр дүнтэй хамтран ажиллах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан бүх үйл ажиллагааг баримтжуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хуваарилах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсвийн зарцуулалтад “Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ” аргачлалын дагуу хяналт тавих;
- Төсвийг үр ашигтай захиран зарцуулах, ялангуяа төрийн байгууллагын дутагдаж байгаа үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэхэд зарцуулж буй өнөөгийн практикийг халах.



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт Хил хязгааргүй алхам ТББ-аас хийсэн Оюутолгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээний 4 дүгээр бүлгийн 4.1 – 4.4 дэх заалтуудын хэрэгжилтэд хийсэн хяналт, мониторингийн үр дүнг хэвлэн нийтэлж байна. Энэхүү мониторинг нь Хил хязгааргүй алхам ТББ-аас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.